



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/244

Номгон

Г
Баянхонгор аймгийн Засаг дарга Э.Энхбатын
ивээл дор зохион байгуулагдах ахмад
настнуудын софт волейболын тэмцээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1.6, 13.1.9, Ахмад настны тухай хуулийн 7.2.13, 11.1.2, Аймгийг хөгжүүлэх 2026-2030 оны үндсэн чиглэлийн 1.2.2.2, Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахмад настнуудын нийгмийн идэвх оролцоо, хөгжлийг дэмжих зорилго бүхий софт волейболын тэмцээнийг 04 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.


2. Тэмцээний мөнгөн шагнал, медаль, өргөмжлөл, шүүгчдийн урамшуулал болон бусад зохион байгуулалтад шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Шаардагдах төсвийн зарцуулалтыг хавсралтаар баталсугай.

4. Софт волейболын тэмцээнийг өндөр түвшинд зохион байгуулахыг Биеийн тамир, спортын газар (Б.Хүрэлчулуун)-т үүрэг болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



626010645

Аймгийн Засаг даргын 2026 оны 07 дүгээр
сарын 22-ны өдрийн 71444 дүгээр
захирамжийн хавсралт.



АХМАД НАСТНУУДЫН СОФТ ВОЛЕЙБОЛЫН
ТЭМЦЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Багийн шагнал	15	232.000	3.480.000	
2	Медаль	90	16800	1.520.000	
Нийт үнэ				5.000.000	

____оОо____